

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2024 оны 09 сарын 12 өдөр

Дугаар: 14

Улаанбаатар хот

Төлөөлөн удирдах зөвлөлийн
гишүүдийг хорооны дарга, гишүүнээр
томилох тухай

Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.18, 80 дугаар зүйлийн 80.2, 81 дүгээр зүйлийн 81.2, Малын индексжүүлсэн даатгалын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2.9, Санхүүгийн зохицуулах хорооны 2022 оны 145 дугаар тогтоолоор батлагдсан “Компанийн засаглалын кодекс”-ын 2.3, 2.4, 5.2, Сангийн сайдын 2017 оны 1 дүгээр тушаалаар батлагдсан “Үндэсний давхар даатгал” ХК-ийн дүрмийн 4.2.3, 4.2.8, Төлөөлөн удирдах зөвлөлийн 2022 оны 21 дүгээр тогтоолоор батлагдсан “Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны журам”-ын 5.2, 5.3, 22 дугаар тогтоолоор батлагдсан “Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх хороодын ажиллах журам”-ын 2.2, 2.4-д заасныг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Сангийн сайдын 2024 оны 6 дугаар сарын 27-ны өдрийн 125 дугаар тушаалаар Төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэлдэхүүнийг шинэчлэн байгуулсантай холбогдуулан “Аудитын хороо”-ны даргаар Ц.Дашдондогийг, гишүүнээр Ц.Батмөнх, М.Өлзийбат нарыг, “Цалин, урамшууллын хороо”-ны даргаар Ц.Батмөнхийг, гишүүнээр Д.Нямрагчаа, Т.Гантогтох нарыг, “Нэр дэвшүүлэх хороо”-ны даргаар Ц.Дашдондогийг, гишүүнээр Д.Нямрагчаа, М.Оюунжаргал нарыг, “Эрсдэлийн хороо”-ны даргаар Д.Нямрагчааг, гишүүнээр М.Өлзийбат, Д.Насанжаргал нарыг тус тус томилсугай.

2. Холбогдох хууль тогтоомжийг үйл ажиллагаандаа мөрдөж ажиллахыг хороодын дарга, гишүүдэд, хариуцсан хорооны үйл ажиллагааг чанартай зохион байгуулж, удирдлагаар хангаж ажиллахыг хороодын дарга нарт тус тус үүрэг болгосугай.

3. Энэ тогтоол батлагдсантай холбогдуулан “Үндэсний давхар даатгал” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2022 оны 12 дугаар сарын 08-ны өдрийн “Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг хорооны дарга, гишүүнээр томилох тухай” 19 дүгээр тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

4. Энэхүү тогтоолыг 2024 оны 9 дүгээр сарын 12-ны өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

ДАРГА



Ч.ТАВИНЖИЛ